

## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

### Нийгмийн даатгалын өвчний газар:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сэргээн засах төвийн болон сувиллын сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

### Сонгон шалгаруулалтын нэр:

Даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төвийн болон сувиллын сонгон шалгаруулалт

Сонгон шалгаруулалтын дугаар: ССШ-01/2024

### Сувилалд тавигдах шаардлага:

- Сонгон шалгаруулалтад өмчийн бүх хэлбэрийн сэргээн засах төвийн болон сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага оролцоно.
- Сонгон шалгаруулалтад оролцох сэргээн засах төв болон сувилал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - o эрх бүхий төрийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд сэргээн засах эсхүл сувиллын тусламж, үйлчилгээг тогтвортой үзүүлдэг байх;
  - o Сонгон шалгаруулалтад оролцогч нь "Рашаан сувиллын бүтэц үйл ажиллагааны MNS 5232:2019" стандартын А хавсралтад заасан хүний нөөцтэй байх;
  - o Сонгон шалгаруулалтад оролцогч нь "Рашаан сувиллын бүтэц үйл ажиллагаа MNS 5232:2019" стандартын Б хавсралтад заасан эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;
  - o Сонгон шалгаруулалтад оролцогч нь "Рашаан сувиллын бүтэц үйл ажиллагаа MNS 5232:2019" стандартын В хавсралтын 2 дахь хэсэгт заасан сэргээн засах эмчилгээг бүрэн үзүүлдэг байх;
  - o "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 31-23-22/ MNS 6055:2009 "Иргэний барилгын төлөвлөлтэд хөгжлийн бэрхшээлтэй иргэний шаардлагыг тооцсон орон зайд, орчин" шаардлага хангасан байх;
  - o "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009 шаардлагыг хангасан байх;
  - o хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас тавьсан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт бүрэн хангагдсан байх;
  - o анхан шатны бүртгэлийн баримт бичиг, статистик мэдээ, мэдээлэл, тайлан гаргах, мэдээлэл дамжуулах, нэхэмжлэх зэрэг үйл ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжсэн байх;
  - o өмчлөлийн аль нэг хэлбэрийн ямар нэгэн маргаангуй байх;
  - o үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг сэргээн засах чиглэлээр үйлчилэх хүрээ, санхүүжих орны тоо, жилд сувилах даатгуулагчийн тоо, санхүүжилтийн хэмжээг урьдчилан тооцож, санхүүжилтийг сэргээн засах тусламж, үйлчилгээнд хэрхэн үр дүнтэй зарцуулах талаар тооцоо, судалгаа, хүрэх үр дүнг урьдчилан төлөвлөсөн байх.

Жич: Эрх бүхий байгууллагын шийдвэрээр дахин сонгон шалгаруулалтад оролцох эрхийг түдгэлзүүлсэн хугацаа дуусгавар болоогүй сэргээн засах төв болон сувилал сонгон шалгаруулалтад оролцох эрхгүй болно.

## **Бурдүүлэх баримт бичиг:**

- Сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлт;
- байршил, тусlamж, үйлчилгээний нэр төрөл, үндсэн үзүүлэлт, орны фонд ашиглалт, дундаж ор хоног, сувилуулагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгасан дэлгэрэнгүй танилцуулга;
- улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
- магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар;
- сэргээн засах төвийн болон сувиллын бүтэц, орон тоог баталсан холбогдох байгууллагын шийдвэр;
- сэргээн засах төвийн болон сувиллын дотоод зохион байгуулалт, байршлын бүдүүвч зураг, гадна, дотор орчны фото зураг эсхүл видео бичлэг;
- хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаа /овог, нэр, албан тушаал, мэргэшлийн байдал, тус сэргээн засах төвийн болон сувилалд ажилласан жил, эмчлэх, сувилах тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, мэргэжлийн диплом, үнэмлэхний дугаар, хуулбарын хамт/;
- сэргээн засах төвийн болон сувиллын үйл ажиллагааны тайлан, тусlamж, үйлчилгээний чанарын албаны төлөвлөгөө, тайлан;
- багаж тоног төхөөрөмжийн жагсаалт, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хийсэн гэрээний хуулбар;
- нийгмийн даатгалын болон татварын өргүй тухай тодорхойлолт /сүүлийн сараар/;
- сэргээн засах төвийн болон сувиллын үйл ажиллагааны тогтвортой байдал, тусlamж, үйлчилгээний чанар, орны фонд эргэлт, сэргээн засах төвийн болон сувилалтай холбоотой өргөдөл гарсан эсэх, түүний үндэслэл, шийдвэрлэлт, гэрээний биелэлт зэргийг тусгасан харьяалах Эрүүл мэндийн газрын тодорхойлолт;
- нийгмийн даатгалын газар, Эрүүл мэндийн газар, Татвар, аудит зэрэг байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүн, тайлан, тавьсан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангаж ажилласан тайлан;
- сонгон шалгаруулалтад оролцогчийн өмчлөлийн маргаангуйг нотолсон Улсын бүртгэлийн газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цахим лавлагаа;
- нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний учир хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид, хөдөлмөрийн чадвар алдалтыг сэргээн засах чиглэлээр үйлчлэх хүрээ, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих орны тоо, жилд сувилах даатгуулагчийн тоо, санхүүжилтийг сэргээн засах тусlamж, үйлчилгээг хэрхэн үр дүнтэй зарцуулах талаар хийсэн тооцоо, судалгаа, хүрэх үр дунг урьдчилан төлөвлөсөн төлөвлөгөө

## **Баримт бичиг хүлээн авах эцсийн хугацаа:**

Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 09 цаг 00 минут хүртэл хүлээн авна.

## **Баримт бичгийг ирүүлэх хаяг, хүлээн авах албан тушаалтан:**

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын 6 давхар 605 тоот өрөөнд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хүлээн авна.
- Цахим шуудангийн хаяг: [undeq@ndaatgal.mn](mailto:undeq@ndaatgal.mn)
- Холбоо барих утасны дугаар 11-328030